

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/95/НА-СТА- ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүү нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Долгорсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn

Аудитор П.Амарсанаа
Утас:261740 Цахим хаяг: amarsanaap@audit.gov.mn

Ажу мэргэн аудит ХХК-ийн захирал Л.Насанбуян
Утас:99093142 Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа	11
3.2 Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/665
танай _____-ны № _____-т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН
ХҮРЭЭЛЭН ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 06 сарын 25-ны өдрийн шийдвэрээр "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-ыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-д нэгтгэхээр, 2025 оны 08 сарын 06-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-ыг татан буулгана" гэсэн шийдвэрүүд гарч байсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Барилга, хот байгуулалтын яамнаас 2022 онд зарласан "Таван толгойн түлш ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрийн талбайд шинээр сайжруулсан шахмал түлшний үйлдвэр барих ТЭЗҮ боловсруулах" зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтад орж, шалгаран

2022/160 дугаартай 299.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий гэрээ байгуулан ажлаа бүрэн гүйцэтгэж, захиалагч талд хүлээлгэн өгсөн боловч тус яам нь гэрээний дагуу төлбөрийг барагдуулаагүй байна. Дээрх авлагыг барагдуулах асуудлыг Эрчим хүчний яам, Сангийн яам, Брилга хот байгуулалтын яам болон хууль хяналтын байгууллагад хандаж байсан бөгөөд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №191/ШШ2025/00637 захирамж, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн захирлын 2025 онд А/70 дугаар тушаал гарган данснаас хасаж, найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, судалгаа, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	1,416,929,932.00	903,500,686.98
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,416,929,932.00	903,500,686.98
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	382,364,399.88	334,280,125.05
1.1.02	Дансны авлага	949,728,370.57	484,529,561.52
1.1.06	Бараа материал	84,837,161.55	82,291,000.41
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	0.00	2,400,000.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,416,929,932.00	903,500,686.98
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	1,011,953,462.82	1,053,661,843.71
1.2.01	Үндсэн хөрөнгө	796,369,633.43	859,257,067.84
1.2.02	Биет бус хөрөнгө	204,856,926.85	183,743,699.53
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	10,726,902.54	10,661,076.34
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,011,953,462.82	1,053,661,843.71
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,428,883,394.82	1,957,162,530.69
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	5,354,311.13	0.00
2.1.1.03	Татварын өр	24,840,393.51	5,593,007.53
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	30,194,704.64	5,593,007.53
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	9,953,603.59	13,698,745.91
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	9,953,603.59	13,698,745.91
2.2	Өр төлбөрийн нийт дүн	40,148,308.23	19,291,753.44
2.3	Эздийн өмч		
2.3.01	Өмч: - төрийн	913,718,777.62	913,718,777.62
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	183,015,690.38	190,950,690.38
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	92,192,981.37	92,192,981.37
2.3.09	Хуримтлагдсан ашиг	1,199,807,637.22	741,428,327.88
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	(458,799,309.34)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	1,199,807,637.22	1,199,807,637.22
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,388,735,086.59	1,937,870,777.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,428,883,394.82	1,957,162,530.69

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	2,266,683,076.54	2,030,963,662.34
02	Борлуулалтын өртөг	232,065,643.18	166,697,682.37
03	Нийт ашиг(алдагдал)	2,034,617,433.36	1,864,265,979.97
05	Хүүний орлого	4,977,104.56	5,935,993.35
8.1	Орлогын дүн	4,977,104.56	5,935,993.35
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,914,047,569.38	2,023,771,729.82
12.1	Зардлын дүн	1,914,047,569.38	2,023,771,729.82
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(72,385.59)	106,126.16
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(1,031,111.14)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	(299,900,000.00)
17.1	Олз, гарзын дүн	(72,385.59)	(300,824,984.98)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	125,474,582.95	(454,394,741.48)
19	Орлогын татварын зардал	7,113,959.81	4,404,567.86
19.1	Хойшлогдсон татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	118,360,623.14	(458,799,309.34)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	118,360,623.14	(458,799,309.34)

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	913,718,777.62	133,648,028.56	92,192,981.37	1,081,447,014.08	2,221,006,801.63
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	118,360,623.14	118,360,623.14
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	49,367,661.82	0.00	0.00	49,367,661.82
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	913,718,777.62	183,015,690.38	92,192,981.37	1,199,807,637.22	2,388,735,086.59
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(458,799,309.34)	(458,799,309.34)
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	7,935,000.00	0.00	0.00	7,935,000.00
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	913,718,777.62	190,950,690.38	92,192,981.37	741,008,327.88	1,937,870,777.25

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,181,499,319.15	2,315,262,971.39
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,140,414,658.77	2,270,231,439.62
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	1,258,200.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	41,084,660.38	43,773,331.77
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,346,885,862.12	2,219,166,916.22
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,134,987,709.58	1,138,156,761.29
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	334,486,738.59	329,293,704.20
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	33,805,896.50	40,418,201.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	48,765,650.11	51,242,602.97
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,240,465.00	13,851,850.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	430,147,454.39	245,093,973.45
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	2,231,920.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	335,451,947.95	398,877,903.31
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(165,386,542.97)	96,096,055.17
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,545,000.00	85,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,545,000.00	85,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,545,000.00)	(85,000,000.00)
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	33,961,960.00	59,180,330.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	33,961,960.00	59,180,330.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(33,961,960.00)	(59,180,330.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(200,893,502.97)	(48,084,274.83)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	583,257,902.85	382,364,399.88
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	382,364,399.88	334,280,125.05

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			2,271,660.1	2,400,000.0	2,037,005.8	(234,654.3)	89.7	(362,994.2)	84.9
1	Эрдэм шинжилгээ, судалгааны	м.төг	224,700.0	750,000.0	852,001.5	627,301.5	379.2	102,001.5	113.6
	Зураг төсөл боловсруулах	м.төг	1,302,784.0	1,100,000.0	644,452.6	(658,331.4)	49.5	(455,547.4)	58.6
	Норм, норматив боловсруулах	м.төг	722,328.8	550,000.0	534,509.6	(187,819.2)	74.0	(15,490.4)	97.2
	Хүүгийн орлого	м.төг	1,847.3		5,936.0	(15,911.3)	27.2	5,936.0	
	Ханшийн зөрүүний олз	м.төг			106.1	106.1		106.1	
2	Нийт орлого	м.төг	2,271,660.1	2,400,000.0	2,037,005.8	(234,654.3)	89.7	(362,994.2)	84.9
3	Нийт зардал	м.төг	2,153,299.5	2,304,407.2	2,491,400.5	338,101.0	115.7	186,993.3	108.1
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	1,914,047.5	2,126,800.0	2,023,771.7	109,724.2	105.7	(102,417.2)	95.2
4	Татварын өмнөх ашиг	м.төг	125,474.6	95,592.8	(454,394.7)	(579,449.3)	(362.1)	(549,987.5)	(575.3)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	118,360.6	86,033.5	(458,799.3)	(576,739.9)	(387.6)	(544,832.8)	(633.3)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	352,452.7	625,769.7	631,441.5	278,988.8	179.2	5,671.8	100.9
	Орлогын татварт	м.төг	7,113.9	8,603.4	11,901.9	4,788.0	167.3	3,298.5	138.3
	НӨТ	м.төг	-	240,000.0	110,974.9	110,974.9		(129,025.1)	46.2
	НДШ	м.төг	163,749.6	177,216.4	329,293.4	165,543.8	201.1	152,077.0	185.8
	ХХАОТ	м.төг	156,405.2	180,000.0	131,958.4	24,446.8)	84.4	(48,041.6)	73.3
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	13,891.1	7,856.4	22,357.3	8,466.2	160.9	14,500.9	284.6
	Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,802.2	2,602.8	2,602.8	800.6	144.4	-	100.0
	Бусад татварт	м.төг	9,490.7	9,490.7	22,352.8	12,862.1	235.5	12,862.1	235.5
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	100,000.0	33,961.4	59,180.3	(40,819.7)	59.2	25,218.9	174.3
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	33	33	30	(3)	90.9091	(3)	90.9
9	Нийт цалингийн сан	м.төг	1,328,056.0	1,312,714.3	1,246,950.0	(81,106.0)	93.9	(65,764.3)	95.0
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,353.7	3,314.9	3,463.8	110.1	103.3	148.8	104.5
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.9	1.0	1.2	0.3	129.0	0.3	127.4
12	Хөрөнгө оруулалт	м.төг	1,545.0		85,000.0	83,455.0	5,501.6	85,000.0	
13	Нийт авлага	м.төг	949,728.4	403,500.0	486,929.5	(462,798.9)	51.3	83,429.5	120.7
	Нийт өглөг	м.төг	40,148.3	10,000.0	19,291.7	20,856.6)	48.1	9,291.7	192.9

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

1 4	Богино хугацаат өр төлбөр	м.төг	30,194.7	10,000.0	5,593.0	24,601.7)	18.5	(4,407.0)	55.9
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	9,953.6	-	13,698.7	3,745.1	137.6	13,698.7	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 ТӨААТҮГ, түүний үйл ажиллагаа

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ нь 1998 онд Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын зорилго нь Монгол Улсын эрчим хүчний салбарын ойрын болон хэтийн хөгжлийн судалгаа хийх, эрчим хүчний байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөл хөтөлбөрүүдийг боловсруулах, шинэ техник, технологи, инновацийг судлан нэвтрүүлэх, норм, норматив, стандартыг боловсронгуй болгох, эрчим хүчний хэмнэлтийн менежмент, инновац нэвтрүүлэх замаар Эрчим хүчний асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагын захиалга, үүрэг даалгаврыг мэргэжлийн түвшинд гүйцэтгэн судалгаа, мэдээллээр ханган эрчим хүчний салбарын хөгжлийг төгөлдөржүүлэх гэж тодорхойлжээ.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний таац боловсруулах, эрчим хүчний бодлого, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгоход шаардлагатай тооцоо, судалгаа, эрчим хүчний балансын судалгаа хийх;
2. Мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, судалгааны материал, мэдээллээр эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг хангах;
3. Эрчим хүчний байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих, магадлал хийх;
4. Хэрэглэгчдийн эрчим хүчний хэрэглээний үр ашгийг тооцох, дүгнэлт гаргах, алдагдлыг бууруулах, эрчим хүч хэмнэх талаар судалгаа хийх, хэмнэлтийн менежментийг нэвтрүүлэх, эрчим хүчний аудитын үйл ажиллагаа эрхлэх;
5. Салбарын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын үр ашгийг урьдчилан тооцож төслийг оновчтой болгох, үнэлэлт дүгнэлт гаргах;
6. Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөх стандарт, нормативын баримт бичиг, техникийн зохицуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах;
7. Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний шинэ техник, технологи, инновацыг судлах, нэвтрүүлэх, нутагшуулах талаар судалгаа хийх;
8. Гадаадын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай хамтран ажиллах, шинэ техник, технологи, ноу хауг харилцан солилцож туршлагаа хуваалцах, сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулах, мэдээллээр холбогдох байгууллагуудыг хангах;
9. Эрчим хүчний салбарт гадаадын зээл, тусламж, гадаадын хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн техник хяналтыг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
10. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8.2, 15.8.5 дахь заалтуудад заасан тусгай зөвшөөрөл олгох асуудлаар урьдчилсан дүгнэлт гаргах үйл ажиллагааг зохион байгуулах;
11. Үйл ажиллагааны явцад боловсруулагдсан баримт бичгүүдийг нэгтгэж, мэдээллийн сан, архивын нэгж бүрдүүлэх;
12. Эрчим хүчний салбарын ажилтнуудыг гадаад, дотоодод сургах, туршлага судлуулах, хурал, семинар, үзэсгэлэнд оролцуулах, зохион байгуулах;
13. Хүрээлэнгийн үндсэн зорилтод нийцсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чиглэсэн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх;
14. Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

3.2 Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын гадаад, дотоод орчин

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ нь Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн. Тус байгууллага нь дотоод хяналтын ажилтан байхгүй, тайлант хугацаанд дээд шатны байгууллагаас дотоод аудитын шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 471.7 сая төгрөгөөр буюу 19.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	382,364.4	334,280.1	(48,084.3)
Авлага	949,728.4	484,529.6	(465,198.8)
Бараа материал	84,837.1	82,291.0	(2,546.1)
Урьдчилж төлсөн зардал	-	2,400.0	2,400.0
Үндсэн хөрөнгө	1,011,953.5	1,053,661.8	41,708.3
Нийт хөрөнгө	2,428,883.4	1,957,162.5	(471,720.9)
Өр төлбөрийн нийт дүн	40,148.3	19,291.7	(20,856.6)

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Богино хугацаат өглөг	30,194.7	5,593.0	(24,601.7)
Урт хугацаат өглөг	9,953.6	13,698.7	3,745.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,388,735.1	1,937,870.8	(450,864.3)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,428,883.4	1,957,162.5	(471,720.9)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгийн данс, авлагын данс, үндсэн хөрөнгийн данс, өр төлбөр, эздийн өмчийн данснууд байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 48.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгууллагын үйл ажиллагаанд өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна. 334.3 сая төгрөгөөс 0.2 сая төгрөгийн үлдэгдэл нь кассанд, 334.1 сая төгрөгийн үлдэгдэл нь банкин дахь харилцах дансны үлдэгдэл байна. Харилцах дансныг үлдэгдлийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан.
- Авлагын үлдэгдэл 484.5 сая төгрөг болж, 465.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны 519.9 сая төгрөгийн авлага төлөгдсөн, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн №191/ШШ2025/00637 захирамж, ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Барилга хот байгуулалтын яамтай холбоотой 299.9 сая төгрөгийн авлагыг данснаас хассан зэрэг нь голлон нөлөөлжээ. Тайлант онд үндсэн үйл ажиллагаатай холбоотой нийт 688.2 сая төгрөгийн авлага шинээр бүртгэгдэж, үүнээс 333.6 сая төгрөгийн авлагыг барагдуулсан
- Бараа материалын дансны үлдэгдэл 82,291.0 сая төгрөг болж өмнөх оноос 2.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд 46.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, Хүрээлэнгийн захирлын А/32, А/60 дугаар тушаалуудаар 4.1 сая төгрөгийн материал акталж, байгууллагын үйл ажиллагаанд 45.3 сая төгрөгийн материал зарцуулсантай холбоотой.
- Урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдэл 2.4 сая төгрөг байгаа нь 2 автомашины дулаан гражийн төлбөрийг гэрээний дагуу урьдчилж төлсөн.
- Үндсэн хөрөнгө дансны дансны үлдэгдэл тайлант онд батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авсан 85.0 сая төгрөг, АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлагийн Эрчим хүчний засаглал төслөөс үнэ төлбөргүй шилжүүлж авсан 34.8 сая төгрөг, ашиглалтын хугацаа дуусч, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, 7.9 сая төгрөгөөр үнийг шинэчилж, орлогоор бүртгэснээр тус тус нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 894 дүгээр тогтоолоор акталж, данс бүртгэлээс хассан 1.1 сая төгрөг, тайлант онд тооцсон элэгдлийн зардал 84.9 сая төгрөгөөр тус тус хасагдсан.
- Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд НӨАТ-ын 3.0 сая, бусад татварын 2.6 сая төгрөгийн өглөгтэй байна. Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 13.7 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр бүртгэлтэй.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 450.9 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн үнийг шинэчилж орлогоор бүртгэсэн 7.9 сая төгрөг болон тайлант онд 458.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласантай холбоотой байна.

Программ хангамжийн талаарх судалгааны үр дүн:

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн нь Ординат ХХК-ийн unicus санхүүгийн программ, зураг төслийн төсөв боловсруулах Estimator Зураг төслийн төсвийн программ, Газардуулгын программ, дулааны горимын тооцоо хийх Модель студио, зураг төслийн төсөв боловсруулах Pover Factory-2022 зэрэг нийт 24.4 сая төгрөгийн өртөгтэй программ хангамжийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Санхүүгийн программын хөгжүүлэлт, засвар үйлчилгээний төлбөрт жилд 0.9 сая төгрөг төлж байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ нь үйлдвэрлэл,

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 719 дүгээр тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 2,400.0 сая төгрөгөөр, зардлыг 2,304.7 сая төгрөгөөр, 86.0 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 85.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 2,036.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,495.4 сая төгрөгийн зардал гарган, 458.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 2,037.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,495.4 сая төгрөгийн зардал гарган, 458.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 363.1 сая төгрөг буюу 15.1 хувиар тасарсан нь зураг төсөл боловсруулах болон зохиогчийн хяналтын ажлын орлогоор 1,100.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 644.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 58.6 хувийн гүйцэтгэлтэй ажилласан нь голлон шалтгаалжээ.

Мөн Засгийн газрын 2025 оны 06 сарын 25-ны өдрийн хуралдаанаар Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ыг Эрчим хүчний үндэсний төв ТӨХХК-д нэгтгэхээр, Засгийн газрын 2025 оны 08 сарын 06-ны өдрийн ээлжит хуралдаанаар “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ыг татан буулгана” гэсэн шийдвэрийг гаргаж байсан нь харилцагч байгууллагуудтай ажил гүйцэтгэх гэрээ хийхээр хэлэлцэж байсан ажлууд хойшлогдох, ажлын явц удаашрах, нарийн мэргэшсэн ажилтнууд өөр байгууллага руу шилжих, ажилтнуудын ажлын бүтээмж буурах зэргээр тус байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн хувьд тодорхой хэмжээнд сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2,495.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 190.7 сая төгрөг буюу 8.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Тайлант оны зардлын гүйцэтгэлд тус хүрээлэнгийн авлагын дансанд бүртгэлтэй байсан 299.9 сая төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр болон ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу автомашин худалдан авахад 85.0 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 458.4 сая төгрөг болж, төлөвлөснөөс 544.4 сая төгрөгөөр дутуу байгаа нь орлогын төлөвлөгөө нийт 363.1 сая төгрөг буюу 15.1 хувиар тасарсан, 299.9 сая төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр болон ТӨБЗГ-ын зөвшөөрлийн дагуу найдваргүй авлагын зардлаар бүртгэсэн нь нөлөөлжээ.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2025 оны 312 дугаар тогтоолын дагуу өмнөх оны 59.2 сая төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ажу мэргэн аудит ХХК-ийн аудитор Д.Наранчимэг, гэрээт аудитор Л.Хонгорзул нар гүйцэтгэж, аудитын чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн, захирал Л.Насанбуян нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор П.Амарсанаа, аудитын менежер Б.Долгорсүрэн, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/26 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2,271.7 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 22.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хүүхдээ асрах чөлөөтэй ажилтнуудын сул орон тоонд томилгоо хийхгүй байх, тэтгэмж олголтыг хязгаарлах зэрэг арга хэмжээ авч ажилласнаар батлагдсан зорилтот төвшний төлөвлөгөөнөөс цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 137.5 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 33.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтээр горим сорил хэрэгжүүлэхэд тус хуулийн хязгаарласан заалтуудтай холбоотой зөрчил илрээгүй болно.

2025 оны санхүүгийн тайлангийн аудитын үндсэн чиглэлийн дагуу хийсэн судалгааны үр дүнгийн талаар:

1. Тус хүрээлэнгийн бүтэц орон тоог Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 231 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд нийт 33 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар батлагдсан, 2025 онд албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.
2. Тус хүрээлэн нь ажилчдадаа өдөрт 10.0 мянган төгрөгийн хоолны, 2.5 мянган төгрөгийн унааны хөнгөлөлт олгож, тайлант онд дээрх зардалд нийт 71.7 сая төгрөг зарцуулсан байна.
3. Тайлант онд тус хүрээлэн нь гадаад томилолтын зардалд нийт 10.8 сая төгрөгийг дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:
 - Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо Олон Улсын Атомын энергийн агентлагаас зохион байгуулсан “Эрчим хүчний ахисан түвшний загварчлалд программ хангамж ашиглах нь” сэдэвт туршлага солилцох семинар;
 - Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй Монгол Улсад тогтвортой эрчим хүчний чадавхыг хөгжүүлэх төслийн сургалт;

- Тайландын Хаант Улсын Бангкок хотноо “Эрчим хүчний ахисан түвшний загварчлал ОУАЭА-ын программ хангамж ашиглах нь” сэдэвт туршлага солилцох семинар.
4. Тус хүрээлэн нь тайлант онд Эрчим хүчний салбарын команд штабын сургалт, худалдан авах ажиллагааны сургалт, монгол бичгийн сургалт, жендерийн сургалтуудад нийт 7.3 сая төгрөг зарцуулсан байна.
 5. Тайлант онд хэвлэл, мэдээлэлтэй холбоотой зардал гаргаагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих нийт 167 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 74.5 сая төгрөгийн 9 гүйлгээ, 34.0 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6-р зүйлийн 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд ил тод тавих мэдээллийг хугацаа хоцроож байршуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Автомашин нийлүүлэх ажлын техникийн үзүүлэлт дээр “... Гаалийн бичигтэй, тухайн компани нь албан ёсны гэрээт борлуулагч байх” гэж заасан боловч шалгарсан компанийн ирүүлсэн тендерийн материалд автомашины гаалийн бичиг болон албан ёсны гэрээт борлуулагч гэдгийг нотлох баримт байхгүй, тендер хянан үзэх журмын дагуу холбогдох маягтуудыг үнэлж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т “Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ”, 26.4.4-т “тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх”, 26.9-д “Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг Сангийн сайдын баталсан холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт: Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан 2025-2026 онд хэрэгжүүлэх “Хамтын гэрээ”-ний 3.17-д “хүрээлэнгийн ажилтан, ахмад ажилтан нь Монгол Улсын төрийн соёрхолт, гавьяат ажилтан цолоор шагнагдсан тохиолдолд салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин хүртэл, Хөдөлмөрийн баатар цолоор шагнагдсан тохиолдолд 20 дахин хүртэл үржүүлсэнтэй тэнцэх нэг удаагийн мөнгөн урамшууллыг захирлын тушаалаар олгоно”, 3.18-д “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн

одонгоор шагнагдвал 600.0 мянган төгрөг, Алтангадас, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдвал 400.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно” гэсэн хуулиас давсан заалтууд оруулсан байна. Дээрх заалтыг үндэслэн тайлант онд хүрээлэнгийн захирлын тушаалаар 3.2 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3 "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн одон медалиар шагнагдсан болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудад урамшуулал олгож байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан шалгуурт тус тус нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад компанийн 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, авлага, өглөг, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин, орлого, зарлагын данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлээр шалгагдагч байгууллагад танилцуулж, баталгаажуулсан. Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 274.2 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 79.8 сая төгрөгийн 2 алдааг залруулсан, 194.4 сая төгрөгийн 3 зөрчлийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 5,354.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу 75.0 хувийн биелэлттэй байна. Өмнөх жилийн аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон хэрэгжилтийг хуулийн хугацаанд ирүүлсэн байна

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	5,354.3	1	5,354.3	100.0
Зөвлөмж	1	-	1		75.0
Нийт дүн	2	5,354.3	2	5,354.3	87.5

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн сайжруулах ажлыг 2026 оны зорилтот түвшний төлөвлөгөөнд тусгасан, хэрэгжих шатанд байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тус хүрээлэн гэрээний дагуу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 2.2 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

ТӨБЗГ-ын 2025 оны 894 дүгээр тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 8 нэр төрлийн 4.4 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасахдаа 2.2 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй байна. Энэ нь НББОУС-16 Үндсэн хөрөнгийн стандарт болон санхүүгийн тайлангийн “оршин байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 9.1 сая төгрөгийн зөрчил² 1.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Эрдэм шинжилгээ бодлого судалгааны хэлтсийн зарим ажилтнуудын ажлыг газрын захирал үнэлж баталгаажуулаагүй байхад 7-8 дугаар сард анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар нийт 1.9 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар үр дүнгийн урамшуулалд олгосон 1.9 сая төгрөгийг ерөнхий нягтлан бодогч Б.Роломжаваар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Төрийн одон медалиар шагнагдсан ажилтнуудад Хүрээлэнгийн захирлын 2025 оны А/67 дугаар тушаалаар 3.200.0 мянган төгрөгийн, Б/54 дүгээр тушаалаар хүүхдээ асрах чөлөөтэй 3 ажилтанд нийт 4,039.2 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3-т "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн одон медалиар шагнагдсан болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудад урамшуулал олгож, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын зөрчсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТӨБЗГ-ын 2025 оны 894 дүгээр тогтоолоор актлагдсан 2,200.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй	1	2,200.0	1	2,200.0				2,200.0				
Дүн	1	2,200.0	1	2,200.0				2,200.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар үр дүнгийн урамшуулал олгосон	1	1,913.6			1	1,913.6						
Төрийн одон медалиар шагнагдсан ажилтнуудад 3.200.0 мянга, хүүхдээ асрах чөлөөтэй 3 ажилтанд нийт 4,039.2 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон	1	7,239.2	1	7,239.2								
Дүн	2	9,152.8	1	7,239.2	1	1,913.6						

Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 онд ил тод байршуулбал зохих нийт 167 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 74,505.9 мянган төгрөгийн 9 гүйлгээ, 34,002.2 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг байршуулаагүй	1	108,508.1			1	108,508.1		
Дүн	1	108,508.1			1	108,508.1		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Автомашин нийлүүлэх ажлын техникийн үзүүлэлт дээр "... Гаалийн бичигтэй, тухайн компани нь албан ёсны гэрээт борлуулагч байх" гэж заасан боловч шалгарсан компанийн ирүүлсэн тендерийн материалд автомашины гаалийн бичиг болон албан ёсны гэрээт борлуулагч гэдгийг нотлох баримт байхгүй, тендер хянан үзэх журмын дагуу холбогдох маягтуудыг үнэлж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй	1	85,000.0			1	85,000.0		
Дүн	1	85,000.0			1	85,000.0		
Нийт дүн	2	193,508.1			2	193,508.1		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 136/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/95/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрдэм шинжилгээ бодлого судалгааны хэлтсийн зарим ажилтнуудын ажлыг газрын захирал үнэлж, баталгаажуулаагүй байхад 7-8 дугаар сард анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 1,913,600.00 /Нэг сая есөн зуун арван гурван мянга зургаан зуун/ төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал, урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар үр дүнгийн урамшуулалд олгосон 1,913,600.00 /Нэг сая есөн зуун арван гурван мянга зургаан зуун/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч Б.Роломжаваар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын захирал /М.Түмэнжаргал/-д хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 583/A0150092

Улаанбаатар хот

САГ-2026/95/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн одон медалиар шагнагдсан ажилтнуудад Хүрээлэнгийн захирлын 2025 оны А/67 дугаар тушаалаар 3.200,000.00 /Гурван сая хоёр зуун мянган/ төгрөгийн, Б/54 дүгээр тушаалаар хүүхдээ асрах чөлөөтэй 3 ажилтанд нийт 4,039,200.00 /Дөрвөн сая гучин есөн мянга хоёр зуун/ төгрөгийн мөнгөн урамшууллыг тус тус олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.3 "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын 1.4.2-т "байгууллагын дотоод журмаар олгодог нэг удаагийн тэтгэмж, урамшууллыг түр зогсоох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Төрийн одон медалиар шагнагдсан болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтнуудад урамшуулал олгож, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаврын зөрчсөн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын захирал /М.Түмэнжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Роломжав/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 584/A0150092

Улаанбаатар хот

САГ-2026/95/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Автомашин нийлүүлэх ажлын техникийн үзүүлэлт дээр "... Гаалийн бичигтэй, тухайн компани нь албан ёсны гэрээт борлуулагч байх" гэж заасан боловч шалгарсан компанийн ирүүлсэн тендерийн материалд автомашины гаалийн бичиг болон албан ёсны гэрээт борлуулагч гэдгийг нотлох баримт байхгүй, тендер хянан үзэх журмын дагуу холбогдох маягтуудыг үнэлж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4-т "Захиалагч тендерийг тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцэх эсэхийг дараах байдлаар хянан үзнэ", 26.4.4-т "тендер шалгаруулалтын баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага хангасан байх", 26.9-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны А/255 дугаар тушаалаар батлагдсан "Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг Сангийн сайдын баталсан холбогдох аргачлал, зааврын дагуу гүйцэтгээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын захирал /М.Түмэнжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Роломжав/ нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 585/А0150092

Улаанбаатар хот

САГ-2026/95/КА-СТА-ТӨҮГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2025 оны 9 дүгээр сарын байдлаар ил тод байршуулбал зохих нийт 167 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 74,505.900.00 /Далан дөрвөн сая таван зуун таван мянга есөн зуун/ төгрөгийн 9 гүйлгээ, 34,002,200.00 /Гучин дөрвөн сая хоёр мянга хоёр зуун/ төгрөгийн зарлагын 4 гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, цахим системд ил тод тавих мэдээллийг хугацаа хоцроож байршуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн ТӨААТҮГ-ын захирал /М.Түмэнжаргал/, ерөнхий нягтлан бодогч /Б.Роломжав/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ДОЛГОРСҮРЭН
Л.НАСАНБУЯН